

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
3.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал	9
3.2. Зардлын данстай холбоотой асуудал.....	9
3.3. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал	10
3.4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ
ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ
ТӨСЛИЙН ҮНДЭСНИЙ ЗАХИРАЛ
П.ЦОГТСАЙХАН ТАНАА

2020.03.09 № 06/753
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл, тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн үндэсний захирал П.Цогтсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналыг заавар, журмын дагуу үнэн зөв толилуулах талаарх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 20-ноос 2020 оны 2 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар “Интер аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 05/2020 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол орны тусгай хамгаалалттай газар

нутгийн менежментийг (орчны бүс болон экологийн коридор) бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл дараах 4 бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газрууд болон тэдгээрийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайжруулах, төслийн бэлтгэл хангах;
- Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Үндэсний болон бүсийн түвшинд Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх;
- Төслийн хүрээнд сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа явуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Интерактив Би Ай” ХХК-ийн “Emerald” программ хангамж ашигладаг байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл нь дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 6,819,242.6 мянган төгрөгөөс тооцон 68,192.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй. Учир нь төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон эрсдэлтэй дансуудад горим хэрэгжүүлэхэд материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,090,678.3 мянган төгрөгөөр буюу 157 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, засгийн газрын хувь оролцооны дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөг/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	516,470.4	1,644,738.4	1,128,268.0
Бараа материал	5,514.9	8,912.7	3,397.8
Үндсэн хөрөнгө	173,125.5	132,138.0	-40,987.6
Нийт хөрөнгө	695,110.8	1,785,789.1	1,090,678.2
Богино хугацаат өр төлбөр	2.7	25,926.5	25,923.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	695,108.1	1,759,862.6	1,064,754.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	695,110.8	1,785,789.1	1,090,678.2

Мөнгөн хөрөнгийн дүн өссөн нь тайлант үед зарцуулагдах ёстой байсан ажлын гүйцэтгэл нь дууссан боловч холбогдох комиссын дүгнэлт, бусад баримт бичгүүд гараагүй тул санхүүжилт олгогдоогүй, мөн дараагийн тайлант үеийн санхүүжилтийг татан авснаас шалтгаалсан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,759,862.6 мянган төгрөг болж 1,064,754.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үед хэрэгжээгүй болон санхүүжилт нь тайлант үед хийгдээгүй ажлуудын санхүүжилтийг хүлээн авсан боловч зардлыг нь гаргаагүйн улмаас тайлант үеийн цэвэр үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 7,643,417.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,923,417.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 5,720,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

2019 оны төсвийг батлахдаа Сангийн яамны зүгээс төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын цалингийн зардлыг “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж”-д багтаан баталсан.

Нийт зардлын 471,500.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 7,171,917.0 мянган төгрөгийг Герман улсын тусламжийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй, эсвэл хойшлогдсон төлөвлөгөөт ажлуудыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Тайлант онд бүрэн хэрэгжээгүй ажлууд

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааны нэр	Төсөв /мянган төгрөг/	Тайлбар
1	Төслийн хүрээнд боловсруулсан менежментийн төлөвлөгөөг хэвлэх /тусгай хамгаалалттай газар нутаг, аялал жуулчлал, Орчны бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, г.м./	83,214.1	Төслийн хүрээнд Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт боловсруулах менежментийн төлөвлөгөөг 2020 оны 01 сард хүлээн авахтай уялдаж, тус тендер 2020 онд хийхээр хойшлогдсон. Тендер шалгаруулалт хугацаа хойшилсон.
2	Дэд төслийн хүрээнд хамгаалалтын захиргаадыг хогны машин, завь, 4 дугуйтай мотоцикл болон цасны мотоцикл зэрэг тээврийн хэрэгслээр хангах	1,170,000.0	Гомдол гарсантай холбогдуулан гэрээ байгуулах ажиллагаа зогссон.
3	Дэд төслийн хүрээнд хамгаалалтын захиргаадыг бага оврын автобус, бохир соруулдаг машин, зөөврийн чингэлэг, хогны машин зэрэг бусад тээврийн хэрэгслээр хангах	1,650,000.0	Шаардлага хангасан тендерийн санал ирээгүй учраас тендер цуцлагдсан. 2020 оны 02 сарын 19-ний өдөр дахин зарласан. Тендерийн нээлтийг 2020 оны 03 сарын 20-ний өдөр 11:00 цагаас хийнэ.
4	Дэд төслийн хүрээнд хамгаалалтын захиргаадыг холбооны хэрэгсэл бусад тоног төхөөрөмжөөр хангах	600,000.0	Тус тендерийг зөвлөх багийн ажлын дүгнэлтэд үндэслэн германы талаас цуцлах шийдвэрийг гаргасан. Тус ажлын төсөв орчны бүсийн ажилд шилжсэн болно. Үнэлэгдэхгүй
5	Дэд төслийн хүрээнд баригдсан хамгаалалтын захиргаа, сургалт мэдээллийн төв, байгаль хамгаалагчийн байруудыг тавилга, компьютер тоног төхөөрөмжөөр хангах	1,350,000.0	Тус хоёр тендерийг нэгтгэж, 2 багцтай нэг тендер болгон зарласан. Багц-1 (компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэх) дээр шаардлага хангасан тендерийн материал ирээгүй учраас цуцлагдсан бөгөөд 2019 оны 12 сарын 04-ний өдөр дахин зарласан. 2020 оны 01 сарын 07-нд тендерийн нээлт хийсэн ба үнэлгээ хийгдэж байгаа. Багц 2 (тавилга нийлүүлэх) дээр 2019 оны 10 сарын 31-ний өдөр "Долоон болдог" ХХК-тай 192,722 еврогийн үнийн дүн бүхий гэрээг байгуулсан.
6	Тусгай хамгаалалттай газар нутгийн Хангайн бүсийн Сургалт, мэдээллийн төвийг тавилга, компьютер тоног төхөөрөмжөөр хангах.	240,000.0	

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,092,799.9 мянган төгрөг буюу 66.6 хувьтай байгаа нь хүснэгт 2-т харуулсан төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэлд зориулж гүйцэтгэлийн үе шатанд 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 220,210.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд зөвлөх багтай холбоотой 703,063.8 мянган төгрөгийн зардал гарсан. Гэвч уг зардлыг хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан Тусгай гэрээний Хавсралт 6-д заасан Зарцуулалтын журмын 3-д даасны дагуу Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн дансаар дамжуулалгүйгээр зөвлөх багийн тусгай дансанд шууд шилжүүлсэн байна. Үүнтэй хамааралтайгаар уг зардалд аудитын зүгээс горим, сорил хэрэгжүүлэх боломжгүй байсан.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан толилуулах ёстой 147 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Гэхдээ, Биологийн олон байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл нь Шилэн дансны цахим хуудасны “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт” хэсгийн “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г оруулахдаа Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчим”-ыг мөрдөж ажлаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 117,146.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Мөн өмнөх оны аудитаар нийт 5 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна.

Хэрэгжээгүй зөвлөмж: Байгаль орчин аялал жуулчлалын яаманд 1,212.4 мянган төгрөгийн үнийн дүнтэй агаар цэвэршүүлэгчийг худалдан авч шилжүүлсэн. Уг хөрөнгийг буцаан төлүүлэх зөвлөмж өгсөн боловч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар уг хөрөнгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд бүртгэх шийдвэр гарсан тул тус яамны хөрөнгөд бүртгэгдсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

- 3.1.1. Илрүүлэлт: Буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаадад 6,329.5 мянган төгрөгийн нэгжийн үнэлгээтэй 14 ширхэг дрон мөн 204,822.8 мянган төгрөгийн өртөгтэй галд тэсвэртэй хувцасыг хүлээлгэн өгөхдөө хөрөнгө хүлээлцэх акт дээр хүлээн авсан хүний гарын үсэг зуруулсан хэдий ч тамга тэмдэг дарж баталгаажуулаагүй байна.
- 3.1.2. Эрсдэл: Зардлын дансны хувьд иж бүрэн байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх ба үүний улмаас Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.5-д заасан анхан шатны баримтын талаарх заалт зөрчигдөх эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл хөрөнгийг хүлээлгэж өгсөн баримт хүчингүйд тооцогдох, хөрөнгө шамшигдах эрсдэл мөн үүснэ.
- 3.1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.
- 3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.2. Зардлын данстай холбоотой асуудал

- 3.2.1. Илрүүлэлт: Тайлант онд дотоод албан томилолттой холбоотой 3,034.3 мянган төгрөгийн шатахууны зардал гарсан бөгөөд уг зардлыг тээвэр, шатахууны зардал гэж бүртгэж толилуулсан байсан. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын хавсралтад дурьдсан дотоод албан томилолт хэсэгт "Төсөвт байгууллагын өөрийн удирдлага болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийн дагуу тусгайлсан удирдамж, програмаар дотоод албан томилолтоор ажиллахад гарах тээврийн зардал, байрны зардал, хоолны зардлыг энэ ангилалд бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.
- 3.2.2. Эрсдэл: Зардлын дансны хувьд илчлэл ба тодруулга батламж мэдэгдэл хангагдахгүй байх ба холбогдох хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх.
- 3.2.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын хавсралтад дурьдсан дээрх заалтыг мөрдөж ажиллах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.3. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд 6,023.4 мянган төгрөгийн тээвэр, шатахууны зардал гаргасан гэж бүртгэсэн. Гэвч уг зардал нь дотоод томилолт болон Улаанбаатар хотод албан хэрэгцээнд гаргасан зардал тул томилолтын зардал, тээвэр, шатахууны зардал гэж тус тусад нь салгаж бүртгэх ёстой байсан.

3.3.2. Эрсдэл: Зардлын дансны хувьд үнэн ба зөв, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх. УСНББОУС 1-ийн дагуу зардлын ангиллыг үнэн зөв толилуулахгүй байх, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллахгүй байх.

3.3.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу шатахууны тооцоог гүйцэтгэлээр нь гаргаж тээврийн хэрэгслийн ашиглалтын зориулалтын дагуу дотоод томилолтын зардал болон тээвэр шатахууны зардал гэж ангилан бүртгэж байх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

3.4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт: Биологийн олон байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл нь Шилэн дансны цахим хуудасны “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт” хэсгийн “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г оруулахдаа Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчим”-ыг мөрдөж ажлаагүй байна.

3.4.2. Эрсдэл: Хууль, дүрэм журам мөрдөгдөхгүй байх, Шилэн дансны цахим хуудсан оруулсан мэдээлэл алдаатай байх, улмаар мэдээлэл хэрэгчлэгчдэд ташаа мэдээлэл өгөх.

3.4.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг мөрдөж ажиллах.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын өгсөн зөвлөмжийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	521,985,330.50	1,653,651,170.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	516,470,370.54	1,644,738,451.33
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	516,470,370.54	1,644,738,451.33
31211	Төрийн банкны харилцах төгрөг	14,315,809.00	51,520,000.00
31221	Төрийн банкны харилцах /евро/	502,154,561.54	1,593,218,451.33
35	БАРАА МАТЕРИАЛ	5,514,959.96	8,912,719.06
35400	Хангамжийн материал	5,514,959.96	8,912,719.06
35410	Бичиг хэргийн материал	1,918,376.00	5,563,075.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,724,091.00	1,724,091.00
35460	Бусад Хангамжийн материал	1,872,492.96	1,625,553.06
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	173,125,529.57	132,137,999.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	173,125,529.57	132,137,999.89
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,475,000.00	98,475,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19,968,540.45	-39,937,080.90
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	69,247,090.00	71,766,090.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,170,207.35	-27,041,970.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,613,940.87	42,613,940.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,101,713.05	-16,742,898.25
39301	Програм хангамж	4,029,959.55	3,004,919.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	695,110,860.07	1,785,789,170.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,700.32	25,926,534.27
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,700.32	25,926,534.27
41300	Өглөг	2,700.32	25,926,534.27
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	25,926,534.27
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,700.32	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	695,108,159.75	1,759,862,636.01
51	Засгийн газрын хувь оролцоо	695,108,159.75	1,759,862,636.01
51200	Хуримтлагдсан үр дүн	695,108,159.75	1,759,862,636.01
51210	Өмнөх үеийн үр дүн	2,162,559,623.34	672,018,328.75
51220	Тайлант үеийн үр дүн	-1,467,451,463.59	1,087,844,307.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	695,110,860.07	1,785,789,170.28

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,320,491,786.48	6,641,171,251.93
11	ТАТВАРЫН ОРЛОГО	490,815,844.14	0.00
114	Нэмэгдсэн өртөгийн албан татвар	490,815,844.14	0.00
114001	Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТО	490,815,844.14	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,285,665,942.34	6,169,671,251.93
120	Нийтлэг татварын бус орлого	813,553,841.48	398,095,000.38
120002	Хүүгийн орлого	28,599,839.31	28,367,032.65
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	784,954,002.17	364,940,187.73
120009	Бусад орлого	0.00	4,787,780.00
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	3,472,112,100.86	5,771,576,251.55
122002	Хандив-Гадаад	3,472,112,100.86	5,771,576,251.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	544,010,000.00	471,500,000.00
131	Нэмэлт санхүүжилтийн орлого	544,010,000.00	471,500,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	544,010,000.00	471,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,919,495,877.98	5,598,293,581.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,398,657,971.90	2,250,983,079.18
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,855,485,801.87	1,798,040,221.40
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	289,308,753.90	0.00
210102	Нэмэгдэл цалин	289,308,753.90	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,549,751.45	30,741,138.40
210201	Тэтгэврийн даатгал	23,151,367.24	20,903,974.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,893,921.20	2,459,291.00
210203	ҮОМШ өвчний даатгал	2,315,136.70	1,967,432.90
210204	Ажилгүйдлын даатгал	554,484.21	491,858.20
210205	Эрүүл мэндийн даатгал	5,634,842.10	4,918,582.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,537,763.80	66,002,985.33
210301	Гэрэл цахилгаан	0.00	1,103,849.00
210302	Түлш, халаалт	0.00	191,776.37
210304	Байрны түрээс	96,537,763.80	64,707,359.96
2104	Хангамж, бараа материалын зардал	16,606,748.27	15,428,854.66
210401	Бичиг хэрэг	5,074,914.00	6,394,071.00
210402	Тээвэр шатахуун	5,000,000.00	4,587,850.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,847,674.27	4,029,693.76
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,804,160.00	417,239.90
210408	Бараа материал акталсны зардал	880,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	48,557,493.62	14,544,275.82
210701	Гадаад албан томилолт	43,355,668.62	7,339,180.82
210702	Дотоод албан томилолт	5,201,825.00	7,205,095.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,310,984,988.53	1,621,175,616.51

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,310,984,988.53	1,615,653,061.24
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	2,488,304.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	175,548.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.00	22,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	2,836,703.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,940,302.30	50,147,350.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,674,801.00	6,640,821.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	42,265,501.30	43,506,529.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	543,450,170.03	452,942,857.78
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	490,815,844.14	364,940,187.73
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	490,815,844.14	364,940,187.73
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	88,002,670.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	88,002,670.05
300001	Нэр данс зөрүү	-278,000.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,634,325.89	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,634,325.89	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,520,837,906.08	3,347,310,502.79
220001	Барилга байгууламж	2,887,750,759.24	2,103,277,957.23
222001	Тоног төхөөрөмж	1,633,087,146.84	1,244,032,545.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-1,599,004,091.50	1,042,877,669.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	338,437,797.56	178,071,395.44
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	338,437,797.56	178,071,395.44
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	206,885,169.65	133,104,758.14
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	206,885,169.65	133,104,758.14
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-1,467,451,463.59	1,087,844,307.26

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,044,999,940.17	5,568,378,532.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,500,989,940.17	5,096,878,532.65
120	Нийтлэг татварын бус орлого	28,877,839.31	28,367,032.65
120002	Хүүгийн орлого	28,599,839.31	28,367,032.65
120009	Бусад орлого	278,000.00	0.00
122	Тусламжийн орлого	3,472,112,100.86	5,068,511,500.00
122002	Хандив тусламж-гадаад	3,472,112,100.86	5,068,511,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	544,010,000.00	471,500,000.00
130	Улсын төвлөрсөн төсвөөс	544,010,000.00	471,500,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	544,010,000.00	471,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,325,078,141.46	1,135,264,181.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,325,078,141.46	1,135,264,181.87
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,272,443,815.57	1,047,244,916.32
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	289,309,053.63	0.00
210102	Нэмэгдэл	289,309,053.63	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,640,058.33	30,741,138.40
210201	Тэтгэврийн даатгал	23,310,954.35	20,903,974.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,930,431.84	2,459,291.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,344,345.59	1,967,432.90
210204	Ажилгүйдлийн даатгал	571,686.25	491,858.20
210205	Эрүүл мэндийн даатгал	5,482,640.30	4,918,582.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,992,793.80	66,002,985.33
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,103,849.00
210302	Түлш, халаалт	0.00	191,776.37
210304	Байрны түрээс	76,992,793.80	64,707,359.96
2104	Хангамж, бараа материалын зардал	17,062,164.27	14,450,283.76
210401	Бичиг хэрэг	5,794,490.00	5,335,490.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	4,999,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,847,674.27	4,029,693.76
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,420,000.00	85,800.00
2107	Томилолт, зочны зардал	48,557,493.62	13,389,680.82
210701	Гадаад албан томилолт	43,355,668.62	0.00
210702	Дотоод албан томилолт	5,201,825.00	13,389,680.82
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	789,207,450.92	915,276,862.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	789,207,450.92	915,276,862.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,674,801.00	7,383,966.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,674,801.00	7,383,966.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,634,325.89	88,019,265.55

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,634,325.89	88,019,265.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,634,325.89	88,019,265.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	2,719,921,798.71	4,433,114,350.78
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,406,448,802.08	3,349,829,502.79
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,406,448,802.08	3,349,829,502.79
220001	Барилга байгууламж	2,907,295,729.24	2,103,277,957.23
222001	Тоног төхөөрөмж	1,489,964,992.84	1,244,032,545.56
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардал	9,188,080.00	2,519,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	128,680,153.91	44,983,232.80
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	335,565,323.56	178,071,395.44
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	335,565,323.56	178,071,395.44
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	206,885,169.65	133,088,162.64
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	206,885,169.65	133,088,162.64
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,557,846,849.46	1,128,268,080.79
87	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,074,317,220.00	516,470,370.54
88	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	516,470,370.54	1,644,738,451.33

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,162,559,623.34	2,162,559,623.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,162,559,623.34	2,162,559,623.34
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,467,451,463.59	-1,467,451,463.59
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	695,108,159.75	695,108,159.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-23,089,831.00	-23,089,831.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	672,018,328.75	672,018,328.75
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,087,844,307.26	1,087,844,307.26
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн бууралт	0.00	0.00	0.00	0.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,759,862,636.01	1,759,862,636.01

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,643,417,000.00	5,092,799,989.84	2,550,617,010.16	66.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,923,417,000.00	1,745,489,487.05	177,927,512.95	90.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,923,417,000.00	1,745,489,487.05	177,927,512.95	90.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,006,400.00	30,741,138.40	4,265,261.60	87.8
Тэтгэврийн даатгал	24,235,200.00	20,903,974.20	3,331,225.80	86.2
Тэтгэмжийн даатгал	2,692,800.00	2,459,291.00	233,509.00	91.3
ҮОМШӨ-ний даатгал	2,154,200.00	1,967,432.90	186,767.10	91.3
Ажилгүйдлийн даатгал	538,600.00	491,858.20	46,741.80	91.3
Эрүүл мэндийн даатгал	5,385,600.00	4,918,582.10	467,017.90	91.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,937,200.00	66,002,985.33	10,934,214.67	85.8
Гэрэл, цахилгаан	2,239,000.00	1,103,849.00	1,135,151.00	49.3
Түлш, халаалт	1,863,000.00	191,776.37	1,671,223.63	10.3
Байрны түрээс	72,835,200.00	64,707,359.96	8,127,840.04	88.8
Хангамж, бараа материалын зардал	19,000,000.00	14,450,283.76	4,549,716.24	76.0
Бичиг хэрэг	7,700,000.00	5,335,490.00	2,364,510.00	69.3
Тээвэр, шатахуун	5,000,000.00	4,999,300.00	700.00	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,500,000.00	4,029,693.76	470,306.24	89.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	85,800.00	1,714,200.00	4.7
Томилолт, зочны зардал	40,020,000.00	6,050,500.00	33,969,500.00	15.1
Гадаад албан томилолт	7,400,000.00	0.00	7,400,000.00	0.0
Дотоод албан томилолт	32,620,000.00	6,050,500.00	26,569,500.00	18.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,724,427,000.00	1,618,341,613.56	106,085,386.44	93.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,724,427,000.00	1,618,341,613.56	106,085,386.44	93.8
Бараа үйлчилгээний бусад зардал	28,026,400.00	9,902,966.00	18,123,434.00	35.3
Бараа үйлчилгээний бусад зардал	28,026,400.00	9,902,966.00	18,123,434.00	35.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,720,000,000.00	3,347,310,502.79	2,372,689,497.21	58.5
Барилга байгууламж	2,095,293,000.00	2,103,277,957.23	-7,984,957.23	100.4
Тоног төхөөрөмж	3,624,707,000.00	1,244,032,545.56	2,380,674,454.44	34.3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,171,917,000.00	516,470,370.54	6,655,446,629.46	7.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,171,917,000.00	5,799,943,284.20	1,371,973,715.80	80.9
Нийтлэг татварын бус орлого	0.00	28,367,032.65	-28,367,032.65	0.0
Хүүгийн орлого	0.00	28,367,032.65	-28,367,032.65	0.0
Тусламжийн орлого	7,171,917,000.00	5,771,576,251.55	1,400,340,748.45	80.5
Хандив тусламж /гадаад/	7,171,917,000.00	5,771,576,251.55	1,400,340,748.45	80.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	471,500,000.00	471,500,000.00	0.00	100.0
Улсын төвлөрсөн төсвөөс	471,500,000.00	471,500,000.00	0.00	100.0

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	471,500,000.00	471,500,000.00	0.00	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	516,470,370.54	-516,470,370.54	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,644,738,451.33	-1,644,738,451.33	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	7	7	0	100.0
Удирдах ажилтан	0	0	0	0.0
Гүйцэтгэх ажилтан	7	7	0	100.0
Үйлчлэх ажилтан	0	0	0	0.0
Гэрээт ажилтан	0	0	0	0.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.28	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	
Шалгагдсан байгууллагын нэр:	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл			Мянган төгрөгөөр	
				САГ-2020/45/СТА-ТХН	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаадад 6,329.5 мянган төгрөгийн нэгжийн үнэлгээтэй 14 ширхэг дрон мөн 204,822.8 мянган төгрөгийн өртөгтэй галд тэсвэртэй хувцасыг хүлээлгэн өгөхдөө хөрөнгө хүлээлцэх акт дээр хүлээн авсан хүний гарын үсэг зуруулсан хэдий ч тамгаар баталгаажуулаагүй байна.	211,152.3	Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	И.Хишигжаргал
Тайлант онд дотоод албан томилолттой холбоотой 3,034.3 мянган төгрөгийн шатахууны зардал гарсан бөгөөд уг зардлыг тээвэр, шатахууны зардал гэж бүртгэж толилуулсан байсан. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын хавсралтад дурьдсан дотоод албан томилолт хэсэгт "Төсөвт байгууллагын өөрийн удирдлага болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийн дагуу тусгайлсан удирдамж, програмаар дотоод албан томилолтоор ажиллахад гарах тээврийн зардал, байрны зардал, хоолны зардлыг энэ ангилалд бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.	3,034.3	Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	И.Хишигжаргал
Тайлант хугацаанд 6,023.4 мянган төгрөгийн тээвэр, шатахууны зардал гаргасан гэж бүртгэсэн байсан. Гэвч уг зардал нь дотоод томилолт болон Улаанбаатар хотод албан хэрэгцээнд гаргасан зардал тул томилолтын зардал, тээвэр, шатахууны зардал гэж тус тусад нь салгаж бүртгэх ёстой байсан.	6,023.4	Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	И.Хишигжаргал
Биологийн олон байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл нь Шилэн дансны цахим хуудасны "Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт" хэсгийн "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г оруулахдаа Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д заасан "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчим"-ыг мөрдөж ажлаагүй байна.	-	Зөвлөмж	Санхүүгийн ажилтан	И.Хишигжаргал
Нийт дүн	220,210.0			